

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Жамбалын Гонгор	Дугаар	L203
Оршин суугаа аймаг	Дорноговь	Оршин суугаа сум	1914
Төрсөн газар	Мандах сум	Төрсөн он	Мандах сум
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Шүтээний хийд	Сүм хийдийн дугаар	ДГМН 099
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 5	Ярилцлага авсан хүн	Ц.Гантулга



Дорноговь аймгийн Мандах сумын Шүтээний хийд

Та аль хийдэд шавилан сууж байсан хүн бэ?

Гонгор: Дашчойлин

Гантулга: Дашчойлин чинь аль хошуу нутгийн хийд вэ?

Гонгор: Ачитын хошууны

Гантулга: Та хийдэд хэдэн настайдаа оров?

Гонгор: Би 5 настайдаа суугаад 16, 17-тойдоо гарсан байхаа Шүтээнд одоо хурал тарахад л гарсан юм

Гантулга: Шүтээний хурал гэхээс гадна Дашчойлон гэж нэрлэдэг байсан уу?

Гонгор: Тийм

Гантулга: Хэзээ ямар хүн байгуулсныг мэдэх үү?

Гонгор: Тэрийг бол мэдэхгүй

Гантулга: Тэр хуучин засаг захиргааны үед Ачит гүний хошуу л гэдэг байсан уу?

Гонгор: Ачит гүний хошуу л гэдэг байсан.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Тэр сүм хийдийн ойр хавьд байгаа газар усны нэрийг та тодруулахгүй юу?

Гонгор: Дөхөм гэж байсан. Дөхөм...

Гантулга: Энэ нөгөө доод талд нь байсан уу?

Гонгор: Өө тийм

Гантулга: Ер нь хаагуураа ?

Гонгор: Зүүнд байсан .Баруунд байсан.Тэгээд цаагуур нь тахидаг овоонууд нь .Тэрний дунд Лүмбийн овоо, Хөх булаг овоо гээд хэдэн тахидаг овоо, тэрнээс нааш яваад Элгэн уул гэж нэг мұхар овоо гээд байсан

Гантулга: Шүтээний хурлын ер нь байрлаж байгаа газар усны байрлал нь хадан толгод дотор юмаа даа?

Гонгор: Тийм толгодын дунд.Өмнөө толгодуудтай, хойноо цул хадтай Бургас гэдэг булагтай, худагтай .Тийм газар байсан

Гантулга: Ойролцоох одоо харьяаны гэх юм уу, лам нар нь ирж очдог тийм хүрээ хийдийг нэрлэвэл?

Гонгор: Лам нар нь ирж очдог хүрээ хийд ч яахав, хөдөө гадаанаас л ирсэн улсууд , зарим нь хийдэд ч очиж сууна ,зарим нь хийдээс ч ирж сууна.Сард наашаагаа ээлжлээд л хурна

Гантулга: Шүтээний хурлын зураг гэж ер нь байсан ,хийдийн тэг зураг гэж ер нь таныг шавь байх үед байсан уу?

Гонгор:Мэдэхгүй .Тэр Готовхаан гэж хийдийн бурхан зурдаг зураач байсан юм.Би тэрийг нь мартчихаж

Гантулга:Шарын хийд байсан уу тиймээ?

Гонгор: Тийм

Гантулга: Ер нь ямар ямар дуган дацантай байсан юм?

Гонгор: Цогчин сүм, Жүдийн сүм ,Маналын сүм, Ламиран сүм,Гүмбэний сүм , Маанийн сүм за тэгээд Чойрын сүм гэдэг чинь одоо Цанидийн гэсэн үг.За тэгээд Гантулга: Ер нь тэр дацангууд нь цогчин дуганы аль аль талд нь хаа хаана байсан бэ?

Гонгор:Тэр баруун урд талд цогчин дуган байсан .Тэгээд баруун талд нь модон дуган, тэгээд жүдийн сахиус .Дацангууд нь модон тийм сахиустай .Тэрний хойно тэр булхан талд нь Гүмбэний сүм, тэгээд Жүдийн сүм зүүн талд нь .Хамгийн зүүн талых нь сүм Жүдийн сүм.Ингээд Очирваань бурхан тахидаг байсан юм.Хамгийн том хамба нь Балжин гэдэг хамба байсан юм

Гантулга: Энэ шүтээний хийдийн гол сахиус нь ямар бурхан байсан юм?

Гонгор: Гомбо сахиус байлаа

Гантулга: Тусдаа сүм байсан уу?

Гонгор:Тэр сахиусууд нь тус тусдаа модон сүмтэй

Гантулга: Ер нь нийтдээ хичнээн хувраг ламтай байсан хийд вэ?

Гонгор: 120 ламтай л байсан юм даа

Гантулга: Тэр нь нөгөө байнга суудаг лам нар байдаг байсан уу?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гонгор: Ирэн очин.Тэгээд нэг өвгөн голдуу настайдуу лам нар нь байнга сууна.Тэгээд ном үзэж байгаа шавь нар бол байнга сууна.Тэгээд л тэр залуу лам нар бол голдуу л ирэн очин .Дандаа тэр хөгшин өвгөн лам нар нь байнгын.

Гантулга: Ер нь голдуу аль хошуунаас ирж шавилж суудаг байсан бэ, лам нар?

Гонгор: Голдуу энэ Ачит гүний хошуу юмуу даа , мэдэхгүй одоо

Гантулга: Ер нь Шүтээний хийдийн хутагт хувилгаан , эрдэмтэн лам нар гэвэл ямар улсуудыг нэрлэх вэ, хийдийн эрдэмтэн лам ?

Гонгор:Тэр Сундуйжад гэж байлаа.Тэр Тож багш байсан юм

Гантулга: Өвгөн Тож уу?

Гонгор: Тийм өвгөн Тож гэж.Сундуйжад, Зандан багш гээд тийм улсууд байлаа.Тэгээд хамгийн түрүүнд Жадамба лам гэж байсан юм даа.Тэрийг би сайн танихгүй

Гантулга: Гэлэн гавж олон байсан уу?

Гонгор: Өө олон гэлэн байсан.Тэрийг тоолж мэдэхгүй

Гантулга: Сайн зурхайч, эмч?

Гонгор: Сайн зурхайч чинь одоо Ёндон гэлэн гэж байлаа.Эмч гэвэл Сандаг лам гэж байлаа

Гантулга:Нэртэй бурханч , зураач .

Гонгор:Тэр нь нөгөө Готовхаанаас өөр байхгүй

Гантулга: Ер нь одоо энэ цогчин дуган, бусад дуган дацангуудын цол лам, ловон, хамба гээд өндөр дээдсүүд байдаг байсан байлгүй?

Гонгор:Хамгийн том нь нь одоо тэр Өвгөн Тож багш л байсан. Тэгээд дараа нь тэр Сундуй гээд байсан, зурхайч .Тэгээд дараа нь манай тэр ах

Гантулга: Ер нь тэр цогчин хийд , тэгээд тэр цогчин биш хийд нь тус тусдаа ялгаатай л байсан байх даа?

Гонгор: Ялгаатай , ер нь тэр цогчин бишд нь тэр Зусангомбо ч гэж байлаа, Ренчин гэлэн гэж байлаа.Их бага хоёр гэлэнтэй л байсан

Гантулга: Даа лам нь ?

Гонгор: Даа лам ч одоо манай ах л лав Мамба даа лам гэдэг байсан

Гантулга: Цогчин даа лам нь?

Гонгор: Цогчин даа лам нь тэр Зундуй лам , Чой лам , Данзан гавж гэж байлаа, Дашдаваа гэж байсан юм.Монхоодой гэж байсан.

Гантулга: Даамал нярав, жасын?

Гонгор:Даамал жасын нярав гэж Дамбаа гуай гэж цанидийн жасын нярав байлаа.Ламирангийн жасын нярав гэж Очирбат гэж хүн байлаа.Цогчин жасын нярав гэж Лхамсүрэн гэж хүн байлаа.Мамбын нярав Балдан гэж байсан/ярилцлага түр завсарлав/...эхлээд цогчинд ор гээд хүүхдүүдийг явуулдаг байлаа

Гантулга: Ер нь бүх л дацангуудад ордог байсан уу?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гонгор:Өө тийм ороогүй дацан байхгүй .Үзээгүй уншлага байхгүй, даанч тогтоосон юм нь бага

Гантулга:Энэ одоо сахиусын сүм гээд байна ш дээ?

Гонгор: Аа тийм

Гантулга: Тэрнээс өөр одоо бурхдуудын тусдаа тэр бурхны сүм гэж байх уу?

Гонгор: Тусдаа байхгүй . Тийм жүдийн сүм сахиусын сүм гэж л ...

Гантулга: Хөмөргийн ?

Гонгор: Хөмөргийн сүм ч гэдэг юмуу ухаандаа.Тэр чинь тус тусдаа сахиустай ш дээ.Тэгээд л хэдэн сүмтэй...Жасын сахиус, мамбын сахиус

Гантулга: Шүтээний хийдэд ер нь ямар ямар дацангууд сургалт явуулдаг байсан бэ? Чойрын, жүдийн ч гэдэг юмуу?

Гонгор:Ер нь Цогчин , Чойр хоёр л голдуу л даа?

Гантулга: Тэгээд л шавь нар нь жүд , зурхай гээд тус тусдаа явдаг биз?

Гонгор: Тэгнэ. Тус тусдаа

Гантулга: Тэгээд л тусгайлан зиндаа болоод л ?

Гонгор:Тийм тусгайлан зиндаа болоод л ..Жүдийн зиндаа, мамбын зиндаа .мамба Чойр хоёрт л их

Гантулга: Өрнө дорнын ном бол тусгайлан заана ?

Гонгор: Өрнө дорнын ном бол тусгайлан заана гэсэн юм байхгүй.Тэгээд л хийдийн ном уншуулна гээд л тэгнэ.Тэгэх дээр нь тэр цогчин сүм дээр ирчихээд л лам нар уншдаг байсан юм

Гантулга:Ер нь ховор байж, хичнээн суваргатай байсан бол?

Гонгор: Нэг суваргатай, ганцхан том суваргатай

Гантулга: Ном барладаг байсан уу, ямар ямар ном барладаг байсан?

Гонгор: Ганжуур , данжуур байна.Тэгээд ном бол их шахуу барладаг байсан .Өшөө чинь юу билээ..өнөө хийморийн дарцагуудыг барлана.Тэгээд бас наймын бар.../инээв/

Гантулга: Өдөр бүрийн уншдаг байсан номнуудаас нэрлээч, тийм тийм ном уншдаг байсан гээд , нэг удаадаа?

Гонгор: За би ч бас мартчихжээ одоо ...

Гантулга: Зүгээр зах зухаас нь нэрлэвэл ,санаж байгаагаа?

Гонгор: Эхлээд л Сундуйн хурал , тэгэд л Гандан гавж гээд л юм уншина.Дэгжид мэгжид тэгээд л

Гантулга: Сар бүрийн одоо сангийн хурлууд шинийн найман, арванд гээд л ?

Гонгор:Тийм шинийн найман, арванд энэ тэр гээд л .Нөгөө лам нар нь мамбын хурал гээд л

Гантулга: Арван таванд?

Гонгор: Тийм арван таван, өөр хэдэнд ч байсан юм..

Гантулга: Хорийн хэднээр ч юмуу?

Гонгор: Хорин хэднээр ч байдаг юмуу

Гантулга: Жилдээ болдог том том хурлууд , цагаан сарын хурал ч байдаг юм уу?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гонгор: Жилдээ одоо цагаан сарын хурал, битүүний хурал том хурал болдог байсан юм.Тэгээд л майдар эргэнэ гээд л юм болно.

Гантулга: Зулын хорин таван ?

Гонгор: Зулын хорин таваан гээд л ганжуур манжуур гээд л ном уншина.Тийм хурал хурдаг байсан юм

Гантулга: Цам гардаг газар байсан үү?

Гонгор: Цам гарахгүй . Цам Гочоо гүний хүрээн дээр л гарна

Гантулга: Майдар бол эргэнэ?

Гонгор:Майдар бол жилдээ л нэг эргэнэ?

Гантулга: Майдар эргэхдээ яг яаж эргэдэг байсан ?

Гонгор: Майдраар нэг их ногоон морин толгойтой тусгай тэргэн дээр бүрхнаа залчаад л тэгээд л нөгөө урдаас нь нэг мөргөчөөд л, хажуугаас нь мөргөчөөд л .Баахан хурал хүрж , түй өргөнө. Тэгээд л хойноосоо нэг мөргөөд л, баруунаасаа нэг мөргөөд л , өмнөөсөө нэг мөргөөд л

Гантулга: Ганжуур эргэдэг байсан үү?

Гонгор: Эргэнэ

Гантулга: Яаж эргэдэг байсан?

Гонгор: Ганжуурыг бол нэг тусгай хүн ганжуураа залж ирээд л тэгээд л лам нар нь мөргөл үйлдээд л .Тэгээд л тусгай модон хуягтай .тэгээд л хэд эргэчээд л буцаж нөгөө номоо сольж үүрээд л, тэгээд л нөгөө 108 ганжуурыг чинь дуустал нь .Тийм юм л болдог байсан .

Гантулга: Цагаан сараар ерөөсөө цэдэр лхамаа л хурах үү ?

Гонгор:Цэдэр лхамаа л

Гантулга: Сүүл шинийн хурал гэж болох үү, өвлийн адаг сарын ?

Гонгор:Өвлийн адаг сарын... тийм цөөхөн хуралтай .Хурдаг байсан юм шиг байгаа юм

Гантулга: Сар сардаа л ?

Гонгор: Тийм сар сардаа л .Сар сард нь л тэрийг чинь хуралддаг

Гантулга: Хайлан хурдаг байсан үү?

Гонгор: Тийм хайлан хурна

Гантулга: Хайлангийн сүм дуган байсан үү?

Гонгор: Хайлангийн тийм дуган байсан .

Гантулга: Хайлан яаж хурдаг байсан

Гонгор: Хайлан одоо тусгай таашаа өмсөөд ?

Гантулга: Нүгнээ?

Гонгор: Нүгнээ тахихад бол яахав махан хоол идэхгүй тэгээд хононо .Махан хоол идэхгүй тэгээд цай цүү уучаад цагаан хоолоо идээд хононо

Гантулга: Тэр бас маанийн хуралтай байсан гэсэн тиймээ?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гонгор: Тийм

Гантулга: Мааниа яаж хурдаг байсан юм?

Гонгор: Мааниа бол маанийн шон гэж байдаг байсан юм...тэрүүнд бол голцуу хөдөөнөөс улсууд цугласан байна.Тэр маанийн овоо гээд маанитын толгойн дээр маанийн овоонд гарна.Тэгээд цагаан идээ эд нараа засаад овоондоо өргөөд л .Тэгээд л тэнчээ нөгөө сайхан уншлагуудаа уншаад л .Хөдөөний улсууд голдуухан цуглана.

Гантулга:Ер нь энэ дуган дацангууд нь ямар материалиар барьсан байдаг юм бэ, тоосгоор барьсан уу, модоор барьсан уу?

Гонгор: Дандаа банзан модон шалтай .Тэгээд л дотроо дандаа багана магана шүхэр мүүхэр нь нэг л их гоё сайхан .Тэгээд л хийц мийц нь тэгээд л тэр хавиараа их л цэвэрхэн, ихэнх нь тоосгоор барьсан

Гантулга:Орой нь ямар оройтой байсан юм , тэр сүм дацангуудын ?

Гонгор: Орой дээр нь одоо ямар гэх юм бэ дээ, дөрвөлжин байшин ш тэй, их гоё л юм байсан юм даа.Одоо тэгээд дотроо нэг хөндий сав , хоосон, ямар хэлбэртэй гэх юм бэ дээ ,арслан марслангийн зурагтай

Гантулга:Модоор барьсан байсан уу, дуган сүмээ?

Гонгор: Модон дуган чиг л байгаа

Гантулга: Ямар ямар дуган, дацан?

Гонгор:Мамбын дацан, аграмбын дацан хоёр чинь модон

Гантулга: Дугуй хэлбэртэй юу, дөрвөлжин хэлбэртэй юу?

Гонгор:Нэг нь дугуй, нэг нь дөрвөлжин

Гантулга: Бусад нь бол дан тоосгоор?

Гонгор:Дан тоосгоор.Тэгээд дандаа дуган дацангуудынхаа ард тус тусдаа сахиус шүтээнийх нь сүмтэй байдаг.

Гомбын сахиус гэдэг ч юмуу, Жүдийн сахиус ч гэдэг юмуу

Гантулга: Дацан болгон хойноо жижиг шүтээний сүмтэй байсан юмуу?

Гонгор: Тийм дандаа модон сүм.дотроо нэг хоёр гурван хүн орж суугаад , мөргөж сүсэглээд л тэндээс хурал номоо аваад л / инээв/

Гантулга:Жамын маарамбын дамжаанууд их байсан уу?

Гонгор: Тийм юмнууд бол энэ зам тавихад л эхэлсэн .Тэгээд л энэ тэндээс лам нар ирнэ.Тийм байсан

Гантулга:Жилдээ ганц л удаа?

Гонгор:Ж илдээ ганц л удаа

Гантулга:Гавжийн дамжаанд юмуу , ...?

Гонгор:Ав адилхан

Гантулга: Нэг удаа дамжаа барихад хэдэн хүнийг?

Гонгор:Тэр үед одоо

Гантулга: Үгүй ээ ер нь эндээс шалгуулж байгаа үед?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гонгор: Шалгуулж байгаа үед ч тэр хэдэн шалгуулж байгаа хүмүүс тэр бүгд цугаараа байна.

Гантулга: Тэгээд л шалгуулаад л дуусангуут зөвшөөрнө?

Гонгор: Тэгээд л болно

Гантулга: Ер нь ямар хичээл ордог байсан?

Гонгор: Тэр ямар хичээл ордог байсныг нь мэдэхгүй

Гантулга: Энэ Төвд Энэтхэг рүү ч юмуу хүрээ рүү том лам одоо сурахаар ч юмуу явдаг байсан уу? Танай хийдээс?

Гонгор: Сурахаар ганц нэг лам явж л байсан. Манай тэр ах лам бас явдаг байсан юм ш дээ. Бас тэр сүүлд нь цогчин дуганаас Данзан гэдэг хүн... Бямбаа гээд хоёулаа тэр хийдэд очиж.... Бас Гончигсүрэн гэдэг хүн гээд ном үзэхээр яваад хотод сууж байгаад тээр жил хүрч ирсэн, тэнд байж байгаад

Гантулга: Энэ ер нь Өлгийн хийдийг бодоход бас энэ хойд хийдийг бодоход Олон хүрэнээс ном тавьдаг байсан гэсэн тиймээ?

Гонгор: Юу тэр Баян овооноос ...тэндээс л ирж том лам нар ирдэг байсан даа

Гантулга: Ямар ямар лам нар ирдэг байсан бэ?

Гонгор: Нэрийг нь мэдэхгүй юм. Энэ шүтээний хамба лам нар л бүх юмаа цэвэрлээд л нэг тусгай тийм байшинд аваачаад л тэгээд л угтаж авъя байгаа гэж бүх хүн нь угтдаг. Тэгээд л угтаж аваад л би ч яахав тэгээд л лам нартай, ... тэгээд л ном өгөөд л

Гантулга: Жас бол их олон байсан уу, дуган бүрийн жас байсан уу?

Гонгор: Дуган бүрийн л жас байсан

Гантулга: Ер нь мал их баян байсан уу?

Гонгор: Аа малтай л байсан

Гантулга: Лам нар нь ер нь хаагуураа амьдардаг байсан, хийдийнхээ?

Гонгор: Хийдийн лам нар нь ер нь голдуу энэ гол усаар, цаагуур нь, энэ уулын хяраар...

Гантулга: Аа газар сайгүй л ?

Гонгор: Газар сайгүй л. Манай ах л лав энэ бэлийн хойд талаар л

Гантулга: Даш дүйчэн улсууд ?

Гонгор: Даш дүйчэн улсууд энэ элэгний эхийн хойд талаар л байна даа

Гантулга: Элэгний эхээр ирж очоод л ?

Гантулга: Голдуу Шүтээний лам нар ?

Гонгор: Шүтээний лам нар л

Гантулга: Та ер нь өглөө босоод орой унтах хүртлээ юу хийдэг байсан бэ?

Гонгор: За яахав дээ, тэгээд л ном үзнэ

Гантулга: За номоо үзнэ?

Гонгор: Тэгээд л нэг одоо хийдийнхээ хуралд суугаад л

Гантулга: Эргэлчид мөргөлчид их цугладаг биз дээ, цагийн хурлаар бол?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гонгор:Өө тэр бол ярих юм байхгүй.Гоё ганган , сайхан морь унасан , морио сайхан гангалсан/инээв/

Гантулга: Хятадын худалдаачид, пүүс мұхлагийнхан байсан уу?

Гонгор : Аа байсан. Энэ Хөх Булагийн тэнд

Гантулга: Та тэгээд хурал хаагдахаар шавилахаа больсон уу?

Гонгор:Хурал хаагдахаар л хөдөө гар ч яваад , мал дээр байж байгаад тэгээд цэрэгт яваад ирсэн дээ

Гантулга:Хэдэн онд сүм хаагдсан юм , ер нь хуучны юугаар нэг хорин хэдэн онд ?

Гонгор:Тийм хорин хэдэн онд л

Гантулга:Хорин долоо найман онд?

Гонгор: Тийм хорин долоо найман оны үед л байх. 43 онд л 21-той цэрэгт явсан ш дээ

Гантулга: Ер нь тэр үед сүм хаагдахад одоо холбож мэдэгдсэн аймаг байсан байх даа?

Гонгор:Аймгаас улс байсан.

Гантулга: Ямар ямар улсууд байсан юм бол ?

Гонгор: Тэр лам нарыг аваад явахад болвол ...Нэг өдөр Шүтээний хамба лам манайд бол Цогчилын хийд гэж ярьдаг юм , том лам нар хурал хийж байхад л Даа ла Шагдарсүрэн гэдэг хүнийг босгоод , тэгээд тэр Батаа гэдэг хүнийг босгоод одоо хурал хийж байхад ш дээ, нөгөө хэд нь яахав байж л байсан. Тэгээд аймгийн захирагч Гомбожав гэдэг хүн сумын дарга Загдсүрэн багийн дарга Жамбалдагва гээд ийм 3 хүн ирээд манай тэр ах лам нарыг аваад, тэгээд тэр Шүтээний бүх лам нарыг гаргаад ... Түрүүн тэр Жамбалдагва гэдэг Загдсүрэн Гомбожаваас нэлээн түрүүн ирээд

Гантулга: Тэгээд ирээгүй юу , тэд нар бол ?

Гонгор: Ирээгүй ээ.Тэгээд манай ах лам 33 настай , урьд нь Дүйнхорын лам байж байхдаа хасагдсан.Шоронд 10 жил сууж байгаад ирсэн, хамгийн зөөлхөн нь

Гантулга: Одоо энэ хуучин Шүтээний хийдийн бурхан сахиус , ном судар нь хадгалагдаж үлдсэн юм байна уу ?

Гонгор: Бараг байхгүй , ганц нэг бурхан үлдсэн байсан ,аймгийн хуралд өгсөн.Аймгийн хурал байсан уу, ямар хурал байсан мэдэхгүй тэгээд өгсөн

Гантулга: Та тэгээд цэрэгт яваад л ,?

Гонгор: Тийм цэрэгт яваад л

Гантулга: Улсад ажиллаад ?

Гонгор:Тийм тэгээд л нэг юм...

Гантулга: Гэр бүлтэй болж?

Гонгор:Тэгээд хурал тарчихаар, манай хийдэд байсан Балдан гэж хүн байсан юм. Тэгсэн чинь манайхан эвлэлийн гишүүн болоод , улаан туг муг дуулаад л залуучууд. Тэгээд намайг ор гээд .Тэгээд хүрээд очсон чинь тэр захирагч нь эсэргүүний хүүхэд авах гэж байна гээд загнаад хөөгөөд гаргасан.Тэгээд эвлэлд очсон чинь бас яахав дээ, эвлэлийн гишүүнд хөөгдөөд, тэгээд гарсан/инээв/

Гантулга: Энэ аймагт Мэргэн вангийн хурал эд нарт та очиж суугаагүй юу?



## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гонгор: Суугаагүй ээ

Гантулга: Ер нь хар болсноос хойш хааяа ном момоо сэргээж үншдаг байсан уу?

Гонгор: Үгүй, энэ хэдэн хүүхдэдээ ном зааж өгөх гэсэн хамаг юмаа мартсан. Хичнээн сайхан олон морь малтай, хэдэн азарга адуутай, хотоороо дүүрэн хоньтой тэгээд л үхэр малтай байсан. Бүгдийг нь хураалгасан/нийгэмчилсэн/ нэг муу охин даага ганц хоёрхон адуутай үлдсэн. Тэгээд аймгийн цаана ...би ганц нэг муу шар цоохор үрээ аваад. Тэгээд л нэг ганц охин даагатай үлдсэн дээ

Гантулга: Тэр дуган дацангуудыг нь бол буулгаад л байсан уу?

Гонгор: Тийм буулгаад л аваад явсан.

Гантулга: Тэгээд тэр дороо буулгасан уу?

Гонгор: Нэлээн байзнасан

Гантулга: Хэдэн жилийн дараа?

Гонгор: Тэгээд нэг хоёр жилийн дараа л. Заримыг нь лацдаад л лацдаад л яваад байсан. Тэгээд л буулгаж аваад л

Гантулга: Бүгдийг нь л буулгаж аваад?

Гонгор: Бүгдийг нь л буулгаж аваад л хэдэн хэмхэрхий дугуй тэр модон сүмийг нь л үлдээсэн дээ. Өөр юу ч үлдээгүй

Гантулга: Тэр дугуй чинь юуны хийд билээ?

Гонгор: Мамбын

Гантулга: Мамбын яг ард уу?

Гонгор: Мамбын ардах нь

Гантулга: Лам нарых нь дугуй юу дөрвөлжин үү?

Гонгор: Нэг нь дугуй

Гантулга: Шавь нарынх нь баруун талд уу?

Гонгор: Баруун талд нь биш, шавь нарынхтай зэрэгцээ дөрвөлжин.

Гантулга: Зүүн талд нь ?

Гонгор: Зүүн талд нь

Гантулга: Шавь нарынх нь яг зүүн талд нь, зэрэгцээ. Жижигхэн жижигхэн дөрвөлжин байсан уу ?

Гонгор: Тийм

Гантулга: Хэдэн сүм байсан тийм ?

Гонгор: Аа нөгөө хэдэн дацан байгаа. Дацан болгоны л ард байсан

Гантулга: Аа эгнээд байсан юмуу?

Гонгор: Тийм яг эгнээ

Гантулга: Дацан бүрийн л сахиус уу?

Гонгор: Дацан бүрийн л сахиус

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Модон сүмүүд байсан уу?

Гонгор: Модон сүмүүд , өндөр гозойсон модон сүмүүд

Гантулга:Шавь нарынх нь бас мод байсан уу?

Гонгор: Мод байсан.

Гантулга: Мамба нь ?

Гонгор: Мамба нь бас мод байсан

Гантулга: Цогчин нь бол тоосго байсан уу?

Гонгор: Цогчин нь бол тоосгон сүм. Тэрний цаана тэр цагийн хурлын хэдэн дацангууд нь жоохон хойшоо.../Ярилцлага түр завсарлав/

Гантулга: Сахиус нь одоо?

Гонгор: Тэрнээс тэр жоохон хойшоо, тоосгон сүм байсан, тэр нүгмээ..

Гантулга: Аа энэ нүгмээ..

Гонгор: За тэрнээс чинь урагшаа нэг хэдэн сүм..

Гантулга: Тэр сахиусын сүм нь ардаа?

Гонгор: Тийм ардаа...

Гантулга: Тэр нь юу билээ?

Гонгор: Жүдийн сүм

Гантулга: Жүд үү?

Гонгор: За тэгээд тэр маарамбын сүм гэдэг чинь нүгмээс ...зэрэгцээ

Гантулга: Баруун талд нь байсан уу?

Гонгор: Зүүн талд нь байсан юм

Гантулга: Хайлангийн сүм ?

Гонгор:Хайлангийн сүм ч тэрний дэргэд л байгаа ш дээ.

Гантулга: Маанийнхаа юу?

Гонгор: Тийм зүүн талд нь

Гантулга: Чойрын сүм нь хаана байдаг юм?

Гонгор:Чойрын сүм нь Цогчин сүмтэйгээ давхар

Гантулга: Аа цогчин , чойр хоёр нь давхар? Жүд нь эндээ, маанийн , ...Дүйнхор гэж байсан уу?

Гонгор: Дүйнхор гэж байгаагүй , манайд.Жүдийн толгой гээд энгэрээд байгааа, тэрний наана жасынхан байсан

Гантулга: Дүйнхор толгой гэж байгаагүй ?

Гонгор: Дүйнхор толгой гэж байгаагүй

Гантулга:Энэ урд толгойн энгэрээр ...?

Гонгор: Жасынхан байсан

Гантулга: Зэрэгцээ юу?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гонгор: Зэрэгцээ байсан

Гантулга: Дөрвөлжин байсан уу?

Гонгор: Өө тэр тийм зууван ч юмуу тийм байсан.

Гантулга: Айлын байшин сав нь хаанаа байсан юм?

Гонгор: Айлын байшин савууд нь энэ байгаа газраас хойшоо хойд захад нэг хэдэн байшин байсан .Тэр урагшаагаа энгэрээд яваад л тэр жасаас урагшаа яваад л хэдэн гэр байшингууд ..

Гантулга:Жасаас урагшаа юу , бас гэр байсан уу?

Гонгор: Гэр байсан

Гантулга: Хийдийн хойгуур гэр байсан уу?

Гонгор: Аа энэ хийдийн хойгуур гэр байсан

Гантулга: Суварга нь ?

Гонгор:Суварга нь тэр Мамба сүмийн баруун хойно

Гантулга: Баруун хойно гэсэн үү ?

Гонгор: Тийм л байна даа .Тэгээд л

Гантулга: Шилмэн уул чинь яг баруун талдаа байгаа биз дээ?

Гонгор: Тийм баруун талдаа.Тэгээд л Жагдарын гээд нэг их ширүүн гол байлаа

Гантулга: За баярлалаа